



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

АУДИТЫН КОД: ХӨА-2022/01/НА-СТА-ТЕЗ

**Мөрөн
2022 он**

Дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар Утас:88883317
Цахим хаяг: Erdnebaatara@audit.gov.mn
Аудитын менежер Б.Тэгшдэлгэр Утас: 99089114
Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Эрдэнэчимэг Утас:99016320
Цахим хаяг: Erdenechibegg@audit.gov.mn
Аудитор Б.Давааням Утас: 92113932
Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Аудитор С.Гансүх Утас: 95908400
Цахим хаяг: Gansukhsa@audit.gov.mn
Аудитор Л.Мандахнаран Утас: 92118277
Цахим хаяг: Mandakhnaranl@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй

БҮЛЭГ-1 ОРОН НУТГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГЫГ САНГИЙН ЯАМНЫ ХЯНАСАН ДҮНГЭЭС 1,897.8 СЯА ТӨГРӨГӨӨР ӨСГӨЖ БАТАЛСАН БАЙНА.

БҮЛЭГ-2 ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ 136.1 ХУВЬ БҮЮУ 5,896.1 СЯА ТӨГРӨГӨӨР ДАВУУЛАН БИЕЛҮҮЛСЭН БАЙНА.

БҮЛЭГ-3 ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ ӨМНӨХ ОНООС 4,964.3 СЯА ТӨГРӨГӨӨР ӨССӨН БАЙНА.

Дүгнэлт:

Зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэлийн тайлан:

Хавсралт:

Холбогдох байгууллагын санал:

Саналд өгөх тайлбар:



Товчилсон үгийн тайлбар

ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
УИХ	Улсын Их Хурал
БСШУС	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайд
БХБС	Барилга, Хот Байгуулалтын Сайд
ХНХС	Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Сайд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
ТЗШ	Тусгай Зориулалтын Шилжүүлэг
ОНХС	Орон Нутгийн Хөгжлийн Сан
ОНӨААҮГ	Орон Нутгийн Өмчит Аж Ахуйн Үйлдвэрийн Газар
СХС	Сум Хөгжүүлэх Сан
МУ	Монгол Улс
СӨБ	Сургуулийн Өмнөх Боловсрол
ЭМТ	Эрүүл Мэндийн Төв
ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
БОАЖГ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газар
ОНХНС	Орон Нутгийн Хөгжлийн Нэгдсэн Сан
ХНХС	Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Сайд
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
БХНСАХЗ	Байгаль Хамгаалах Нөхөн Сэргээх Арга Хэмжээний Зардал
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар
ГХБХБГ	Газрын Харилцаа Барилга Хот Байгуулалтын Газар
ОНӨГ	Орон Нутгийн Өмчийн Газар
БХНСАХЗ	Байгаль Хамгаалах Нөхөн Сэргээх Арга Хэмжээний Зардал
БТСХ	Биеийн Тамир Спорт Хороо
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн Болон Орон Нутгийн Өмчийн Хөрөнгөөр Бараа Ажил Үйлчилгээ Худалдан Авах Тухай



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/05

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/87 дугаар тушаал, 2018 оны А/207 дугаар “Эрх үүрэг шилжүүлэх тухай” тушаал, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3.4.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн тушаах нь:

1. Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газар, Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Ш.Идэрбаясгалан/-д зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор /Г.Эрдэнэчимэг/-т үүрэг болгосугай.
6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЗБААТАР



Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн А/05 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага

№	Албан шаардлагын дугаар	Утга
1	46/A2260435/ХӨА-2022/01/НА-СТА-ТЕЗ	Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

--o0o--



НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.3.1-д тодорхойлогдсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан цаглаврын хугацаанд Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийсэн.

Аудитын зорилт:

Хөвсгөл аймгийн 2021 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулан Хөвсгөл аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн 2021 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөлт үндэслэлтэй эсэх
- Орон нутгийн 2021 оны төсвийн орлогын төлөвлөгөө биелсэн эсэх
- Орон нутгийн 2021 оны төсвийг батлагдсан төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх

Аудитын хамрах хүрээ:

Хөвсгөл аймгийн ТЕЗ-ын 2021 оны орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайлан, судалгаа, харьяа байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэл болон бусад баримт материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ аудитын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/70 тушаалаар баталсан “Санхүүгийн аудитын журам”, 2021 оны А/111 тушаалаар баталсан “Ерөнхий чиглэл, аргачилсан зөвлөмж батлах тухай”, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгосны зэрэгцээ холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Өрийн удирдлагын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2020 оны 168 дугаар тогтоол
- Засгийн газрын 2020 оны 78 дугаар тогтоол
- Засгийн газрын 2020 оны 187 дугаар тогтоол
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 05 дугаар тогтоол
- 2021 оны 08 дүгээр сарын 21-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоол
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд



Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр хэрэгжүүлэн, ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитор Б.Давааням, С.Гансүх, Л.Мандахнаран нар 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дүгээр сарын 29-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн болно. Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлд 2021 оны төсвийн жилд Хөвсгөл аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 18,661.5 сая төгрөгөөр, 17 дугаар зүйлд ОНХС-д олгох шилжүүлгийг 9,192.0 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг 70,825.9 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Хөвсгөл аймгийн 2021 оны орон нутгийн төсвийн орлого, зарлагыг 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн аймгийн ИТХ-ын хуралдааны 05 дугаар тогтоолоор, 2021 оны орон нутгийн төсвийн эх үүсвэрийг 118,725.6 сая төгрөгөөр, урсгал зардлыг 105,412.7 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 10,890.2 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 2,422.7 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолоор Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2.1¹ заалтыг үндэслэн 2021 оны төсөвт 1 удаа тодотгол хийж Хөвсгөл аймгийн **2021 оны төсвийн орлогыг 127,163.9 сая төгрөг, төсвийн зарлагыг 127,163.9 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.**

Аймгийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн А/281, 12 дугаар сарын 06-ны өдрийн А/603, 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 захирамжаар тус тус орон нутгийн төсөвт зохицуулалт хийсэн байна.

Аймгийн 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт орлогын гүйцэтгэлийг 123,851.7 сая төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг 118,565.8 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь заалтын дагуу тохируулсан аккрузал сууриар тайлагнасан байна.

Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тайлангийн нийт зардлын дүнг сонгов.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 1,778.5 сая төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

Дээрх ажлын баримтад материаллаг байдлын суурь үзүүлэлт, хувь хэмжээг сонгосон шалтгаан, тайлбар болон материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзэх шалтгаан, тайлбарыг тусгасан болно.

Санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,333.9 сая төгрөгөөр тогтоолоо. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг шинэчлэн тогтоогогүй болно.

¹ Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон



БҮЛЭГ 1: Орон нутгийн төсвийн орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 1,897.8 сая төгрөгөөр өсгөж баталсан байна.

Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулиар 2021 оны төсвийн жилд Хөвсгөл аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 18,661.5 сая төгрөгөөр, 17 дугаар зүйлд ОНХС-д олгох шилжүүлгийг 9,192.0 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг 70,825.9 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн 2021 оны төсвийн төсөл боловсруулах удирдамжид заасан зарчмын хүрээнд 2021 оны орон нутгийн төсвийн орлогыг 10,730.6 сая төгрөгөөр боловсруулж Төсвийн тухай хуулийн 8.4.3²-д заасны дагуу Сангийн Яаманд хүргүүлсэн байна.

Сангийн яаманд татварын орлогыг 10,730.6 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 567.8 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 35.0 сая төгрөгөөр төлөвлөж санал хүргүүлснийг 3,705.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн орон нутгийн 2021 оны суурь орлогоор нийт 14,436.0 сая төгрөгөөр хянасан байна.

Орон нутгаас хүргүүлсэн суурь орлогын төсвийн төслийг өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэл, Сангийн яамны хянасан дүнтэй зэрэгцүүлэн харуулбал:

Хүснэгт №-1. Суурь орлогын төсөв /сая төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	2021 он			
	СЯ-нд хүргүүлсэн дүн	СЯ-ны хянасан дүн	АИТХ анх баталсан дүн	Зөрүү
	3	4	5	5-4
Нийт орлого	10,730.6	14,436.0	16,333.8	1,897.8
1.Татварын орлого	10,127.8	13,323.0	14,848.9	1,525.9
2.Татварын бус орлого	567.8	1,078.0	1,448.7	370.7
3.Хөрөнгийн орлого	35.0	35.0	36.2	1.2

Аймаг, сумын ИТХ-аар Сангийн яамны хянаж ирүүлсэн дүнгээс 2021 оны суурь орлогын төсвийг 1,897.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, орон нутгийн 2021 оны суурь зардлыг 46,120.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Орон нутгийн суурь зарлагын төслийг өмнөх оны төсөв, Сангийн яамны хянаж баталсан дүнтэй зэрэгцүүлэн харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №-2 Орон нутгийн суурь зарлага /сая. төгрөг/

Төсвийн зарлагын төрөл	2020 он		2021 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	СЯ-нд хүргүүлсэн дүн	СЯ-ны хянасан дүн	Аймаг баталсан дүн
Орон нутгийн суурь зарлагын дүн	52,643.5	47,716.0	52,470.2	32,749.8	46,120.2

Хөвсгөл аймгийн ИТХ-ийн хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолоор орон нутгийн суурь зарлагыг батлахдаа 2020 оны гүйцэтгэлээс 1,595.8 сая төгрөгөөр бууруулж, Сангийн яамны хянасан дүнг 13,370.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Хөвсгөл аймгийн орон нутгийн 2021 оны төсвийн нийт зардлыг аймаг, сумын ИТХ-аар анх баталсан дүнг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №-3. Хөвсгөл аймгийн орон нутгийн төсвийн зардал анх батлагдсан дүн /сая төгрөг/

№	Үзүүлэлт	2021 оны баталсан
1	Орон нутгийн төсөв	20,219.2
2	Улсын төсвийн санхүүгийн дэмжлэг	17,553.9
3	ОНХС –ийн шилжүүлэг	9,192.0
4	Тусгай зориулалтын шилжүүлэг	70,825.9

² Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Улсын Их Хуралд хүргүүлэх;



5	ЭМДС-аас санхүүжих	934,6
Нийт орлогын дүн		118,725.6
1	Урсгал зардал	105,412.7
2	Хөрөнгийн зардал	10,890.2
3	Эргэж төлөгдөх цэвэр зээл	2,422.7
Нийт зардал		118,725.6

Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 57.2³. заалтыг ханган урсгал зардлыг 105,412.7 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 10,890.2 сая төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээл 2,422.7 сая төгрөг нийт 118,725.6 сая төгрөгөөр анх баталсан байна.

Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газраас ирүүлсэн ТЕЗ нарын 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл бэлтгэх заавар, удирдамжид заасан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн болон татварын хууль тогтоомжийг мөрдөж, орлогын боломжит эх үүсвэрүүдийг дайчлах, бааз суурийг өргөжүүлэх зорилтуудыг баримтлан ажилласан байна.

Орон нутгийн төсвийн зарлагыг 8,438.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгол хийсэн байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолоор Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2.1⁴ заалтыг үндэслэн 2021 оны төсөвт тодотгол хийж 8,438.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

Хөвсгөл аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн тодотгосон төлөвлөгөөг 2020 оны гүйцэтгэл болон 2021 оны зорилтот түвшинтэй харьцуулахад дараах байдалтай байна:

Хүснэгт №-4 /Төсвийн тодотгол хийсэн тооцоо/ /сая төгрөг/

Орлогын төрөл		Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү	
				дүн	Хувь
Нийт орлого		118,725.60	127,163.80	8,438.20	107.1
1	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	70,825.90	72,672.60	1,846.70	102.6
2	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	9,192.00	9,641.30	449.30	104.9
3	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	17,553.90	18,661.50	1,107.60	106.3
4	Орон нутгийн орлого	20,219.20	25,253.80	5,034.60	124.9
5	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	934.6	934.6	0.00	100

Хүснэгтээс харахад: Орон нутгийн төсвийг тодотгож батлахдаа анх баталсан дүнгээс 8,438.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2⁵, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ыг үндэслэн аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/281 дугаар захирамжаар, 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/603 дугаар захирамжаар, 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 дугаар захирамжаар тус тус 3 удаа төсөвт зохицуулалт хийсэн байна. Үүнд:

- Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/281 дугаар захирамжаар орон нутгийн 15 байгууллагын төсвийн зардлын зүйл хооронд 44.9 сая төгрөгийн, эрүүл мэндийн 7 байгууллагын зардлын зүйл хооронд 5.7 сая төгрөг, боловсролын салбарын 16 байгууллагын зардлын зүйл хооронд 96.5 сая төгрөгийн зохицуулалт хийсэн.
- 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/603 дугаар захирамжаар сумын эрүүл мэндийн 10 байгууллагын зардлын зүйл хооронд 15.1 сая төгрөгийн зохицуулалт хийсэн.
- 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 дугаар захирамжаар орон нутгийн 44 байгууллагын төсвийн зардлын зүйл хооронд 107.2 сая төгрөгийн, төсөв захирагч хооронд

³ Орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ.

⁴ дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон

⁵ Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно,



252,7.0 сая төгрөгийн, эрүүл мэндийн 3 байгууллагын зардлын зүйл хооронд 2.2 сая төгрөг, байгууллагын зардлын хооронд 15.0 сая төгрөгийн, ерөнхий боловсролын байгууллагуудын зардал хооронд 370.4 сая төгрөгийн нэмэх, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын зардал хооронд 520.4 сая төгрөгийн хасах зохицуулалтыг хийсэн.

Зардлын төсөвт дараах материаллаг дүнгээр зохицуулалт хийсэн байна. Үүнд:

Хасах зохицуулалт: Цалин болон нэмэгдэл урамшууллын зардал 255.9 сая төгрөг, НДШ-ийн зардал 36.5 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 134.6 сая төгрөг, Норматив зардал 1,654.5 сая төгрөг, томилолт, зочны зардал 23.0 сая төгрөг, төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, дэмжлэгийн зардал 432.8 сая төгрөгийн хасах зохицуулалт хийсэн.

Нэмэх зохицуулалт: Эд хогшил, урсгал засварын зардалд 1,619.5 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 502.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 152.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 201.2 сая төгрөгийн нэмэх зохицуулалт хийсэн.

Аймгийн ТЕЗ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.2. “төсвийн төвлөрүүлэн захирагч нь саналаа харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх”, 42.4. “Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна” заалтын дагуу боловсролын салбарын байгууллагуудын ТЗШ-ийн байгууллагуудын төсвийн хөтөлбөрийн хооронд зохицуулалт хийх зөвшөөрлийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 1а/5843 алба тоотоор авсан байна.

Ковид-19 цар тахалтай тэмцэхэд тогтоосон хөл хорионы улмаас хичээл сургалтын үйл ажиллагаа түр зогссоноос хэмнэгдсэн 1,654.5 сая төгрөгийн норматив зардлаас хөрөнгө бэлтгэх, сургуулийн үдийн хоол бэлтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад зориулж 1,619.5 сая төгрөгийн эд хогшил худалдан авах зардалд зохицуулалт хийж төлөвлөсөн байна.

Аймгийн ТЕЗ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 –т зааснаар төсвийн хөтөлбөр хооронд, төсвийн шууд захирагчийн төсөв хооронд, төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчийн хооронд төсвийн зохицуулалт хийсэн байна.

БҮЛЭГ 2: ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ 136.1 ХУВЬ БУЮУ 5,896.1 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВУУЛАН БИЕЛҮҮЛСЭН БАЙНА.

Хөвсгөл аймгийн орон нутгийн орлого 5,896.1 сая төгрөгөөр давж биелсэн боловч гурван нэр төрлийн орлого тасарсан байна.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан 127,163.8 сая төгрөгийн орлого гүйцэтгэлээр 123,851.7 сая төгрөг төвлөрч төлөвлөгөө 97.4 хувиар буюу 3,321.1 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн орлогын гүйцэтгэл дараах байдалтай байна

Хүснэгт №-5 Төсвийн гүйцэтгэлийг санхүүжүүлэх эх үүсвэр /сая.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэлээр	2021 он		2021 оны биелэлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Тусгай зориулалтын шилжүүлэг	68,520.9	72,672.6	71,893.9	-778.7	98.9
Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	6,729.9	9,641.3	9,641.3	0.0	100.0
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	28,161.0	18,661.5	18,661.5	0.0	100.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,598.9	25,253.8	22,918.4	-2,335.4	90.8
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	724.3	934.6	736.6	-198.0	78.8
Дүн	139,735.0	127,163.8	123,851.7	-3,312.1	97.4

Төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийн ихэнх хэсгийг буюу 55.0 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, 16.0 хувийг орон нутгийн төвийн орлого, 14.0 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 7.0 хувийг орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг тус тус эзэлж байна.



Хүснэгт №-6 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	14,848.9	20,099.1	5,250.2	135.4
Татварын бус орлого	1,448.7	2,022.3	573.6	139.6
Хөрөнгийн орлого	36.3	108.6	72.3	299.2
Нийт дүн	16,333.9	22,230.0	5,896.1	136.1

Орон нутгийн төсвийн орлогын 90.0 хувь нь татварын орлогоос, 10.0 хувь нь татварын бус орлогоос, 0.1 хувь нь хөрөнгийн орлогоос тус тус бүрдсэн байна.

2021 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулан хүснэгтээр харуулбал: /сая төгрөг/

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2020 он	15,324.9	18,147.3
2021 он	16,333.8	22,230.0
Өөрчлөлт	1,008.9	4,082.7

Хүснэгтээс харахад: 2021 оны төсвийн орлогын төлөвлөлт 2020 оноос 1,008.9 сая төгрөгөөр, харин орлогын гүйцэтгэл 2020 оноос 4,082.7 сая төгрөгөөр өссөн нь жил бүр татварын бааз суурь өсөн нэмэгдэж байгаатай холбоотой байна.

Тайлант онд орон нутгийн орлого нийт дүнгээрээ 5,896.1 сая төгрөгөөр давж биелэхэд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутгах ХХОАТ-ын орлого 1,146.8 сая төгрөгөөр, Ойн нөөц ашигласны төлбөр төлбөрийн орлого 1,139.9 сая төгрөгөөр, Малд ногдуулах албан татварын орлого 795.4 сая төгрөгөөр материаллаг хэмжээгээр нөлөөлсөн байна.

Орон нутгийн орлогоос Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 11,0 сая төгрөгөөр, Хог, хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 36.7 сая төгрөгөөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 14.9 сая төгрөгөөр тасарсан байна. /Хавсралт 4/

Орон нутгийн орлогыг бүтцээр нь харуулбал:

Улсад төвлөрүүлэх орлого 50.9 сая төгрөгөөр, аймагт төвлөрүүлэх орлого 1,788.4 сая төгрөгөөр, сумдын орлогын төлөвлөгөө 3,234.7 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №-8. Орлогын төлөвлөгөөний биелэлт /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Нийт дүн		Биелэлт	
		Төлөв	Гүйц	Зөрүү	/хувь/
1	Сумын төсвийн орлогын дүн	6,392.5	9,627.3	3,234.8	150.6
2	Аймгийн төсвийн орлогын дүн	9,941.3	12,602.7	2,661.4	126.8
3	Улсын төсвийн орлого	7,086.3	7,137.2	50.9	100.7

Сумын орлого давж биелэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Галт суманд 80.0 сая төгрөг, Жаргалант суманд 216.0 сая төгрөг, Эрдэнэбулган суманд 160.0 сая төгрөг нийт 456.0 сая төгрөгийн ойн дагалдах баялаг болох 2020 оны үйлдвэрлэлийн зориулалттай самар бэлтгэх гэрээний үлдэгдэл санхүүжилтийн орлого;
- Шонхрын орлого 382.2 сая төгрөг орсон;
- Малын тоо толгойд ногдуулах албан татвар шинээр тусгагдан 1,129.9 сая төгрөг орж ирсэн зэрэг нь орлого давж биелэхэд нөлөөлсөн байна;

Бүх сумдын орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн бөгөөд Тариалан сумаас бусад сумдын орлогын төлөвлөгөө тасарсан байна. Сумын орлогын төлөвлөгөөний биелэлтийг Хавсралт 1-ээс харна уу.

Аудитын илрүүлэлт:

- Тариалан сумаас бусад сумдын орлогын төлөвлөгөө нэр төрлөөр бүрэн биелээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. “Хуулийн дагуу улс, орон нутгийн



төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” заалттай нийцэхгүй байна.

- Шинээр хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Малын татварын орлогыг Хатгал тосгон болон Алаг-Эрдэнэ, Арбулаг, Баянзүрх, Галт, Жаргалант, Их-Уул, Ренчинлхүмбэ, Тосонцэнгэл, Түнэл, Улаан-Уул, Чандмань-Өндөр сумдууд нь орон нутгийн орлогод төлөвлөөгүй байна.

Энэ нь татварын судалгаа, тооцоогүй, аймгийн ИТХ-аас өгсөн чиглэл, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлээгүйг харуулж байна.

Сум хөгжүүлэх сангийн төлөвлөгөө гүйцэтгэлийн талаар:

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 1,876.4 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 2,336.4 сая төгрөг орж хэрэгжилт 124.5 хувийн биелэлттэй, зээл олгохоор 2,517.5 сая төгрөг төлөвлөснөөс 1,128.7 сая төгрөгийн зээл олгож 1,388.8 сая төгрөгийн зээл олгоогүй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн төлөлт 89.7 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 170.1 сая төгрөг орж хэрэгжилт 189.6 хувийн биелэлттэй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт төлөвлөгөөнөөс 460.0 сая төгрөгөөр давж төлөгдсөн нь Монгол банкны зээлийн мэдээллийн санд зээлдэгчийн мэдээлэл орсон, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж чанаргүй зээлдэгчтэй дахин гэрээ байгуулж хяналт хийсэн нь нөлөөлсөн байна.

БҮЛЭГ 3: ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ ӨМНӨХ ОНООС 4,964.3 САЯ ТӨГРӨГӨӨР ӨССӨН БАЙНА.

Төсийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл 93.2 хувьтай байна.

Хөвсгөл аймгийн 2021 оны зардлын төлөвлөгөө 127,163.9 сая төгрөг, гүйцэтгэлээр 118,565.6 сая төгрөг буюу 93.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 118,565.6 сая төгрөг ба өмнөх онтой харьцуулахад 4.3 хувь буюу 4,964.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №-9. Төсвийн гүйцэтгэлийг зардлын нэр төрлөөр харуулбал: /сая төгрөг/

Зардлын үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны нэгтгэсэн тайлангаар			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	113,601.2	127,163.9	118,565.6	-8,598.3	93.2
А.УРСГАЛ ЗАРДАЛ	103,059.6	111,200.4	109,171.1	-2,029.3	98.2
Бараа ажил үйлчилгээний зардал	97,713.4	104,903.6	102,960.5	-1,943.1	98.1
Татаас	1,713.8	1,874.6	1,855.6	-19.0	99.0
Урсгал шилжүүлэг	3,632.4	4,422.2	4,355.0	-67.2	98.5
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,070.4	13,446.2	8,269.8	-5,176.4	61.5
В.ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,471.2	2,517.3	1,124.7	-1,392.6	44.7

Зардлын гүйцэтгэлийг бүлгийн дүнгээр авч үзвэл:

- Цалин шимтгэлийн зардал 98.6 хувь, тогтмол зардал 98.1 хувь, хангамжийн зардал 97.5 хувь, норматив зардал 89.8 хувь, эд хогшил, урсгал засварын зардал 98.4 хувь, татаас шилжүүлэг 99.0 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 92.1 хувь, урсгал шилжүүлэг 98.5 хувь, хөрөнгийн зардал 61.5 хувь, сум хөгжүүлэх сангийн зээлийн олголт 44.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 10. Орон нутгийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийг аймаг, сумаар харуулбал: /сая төгрөг/

№	Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Үүнээс:		
					Эргэж төлөгдөх зээл	Хөрөнгийн зардал	Урсгал зардал
1	Сумын дүн	108,698.3	103,346.4	-5,351.7	1,124.7	3,682.5	98,539.2



2	Аймгийн дүн	18,465.6	15,219.2	-3,246.4	0.0	4,587.3	10,631.9
	Дүн	127,163.9	118,565.6	-8,598.1	1,124.8	8,269.8	109,171.3

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 8,598.1 сая төгрөгийн хэмнэлт гарсан нь дараах зардлуудын гүйцэтгэлтэй холбоотой байна. Үүнд:

- Бараа, ажил үйлчилгээний зардал 1,943.1 сая төгрөг
- Татаас санхүүжилт 19.0 сая төгрөг
- Урсгал шилжүүлэг 67.2 сая төгрөг
- Хөрөнгийн зардал 5,176.4 сая төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Төсвийн зардал хэмнэх гол шалтгаан Ковид 19 цар тахлын улмаас байгууллагуудын үл ажиллагаа хумигдсан, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа удааширсан, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн сан зарим зардлын гүйлгээний эрх хязгаарласантай холбоотой байна.

Хүснэгт №-11. Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг өмнөх онуудтай харьцуулбал: /сая төгрөг/

Зардлын нэр төрөл	2020 он	2021 он	Өөрчлөлт
Урсгал зардал	103,059.6	109,171.3	6,111.7
Хөрөнгийн зардал	9,070.4	8,269.8	-800.6
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	1,471.2	1,124.8	-346.4
Зардлын дүн	113,601.3	118,565.9	4,964.6

2021 оны гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад урсгал зардал 6,111.7 сая төгрөгөөр өссөн бол, хөрөнгийн зардал 800.6 сая төгрөгөөр буурсан, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардал 346.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №-12 Төсвийн зарлагыг зардлын зүйлээр харуулбал /сая төгрөгөөр/

Зардлын зүйл	Жилийн төсөв	Гүйцэтгэл	Хувь
НИЙТ ЗАРЛАГА	127,163.9	118,238.9	93.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	66,463.4	66,012.2	99.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,943.1	8,748.3	97.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,316.1	11,097.4	98.1
Хангамж, бараа материалын зардал	2,833.4	2,763.0	97.5
Норматив зардал	3,581.7	3,215.0	89.8
Эд хогшил, урсгал засварын зардал	4,292.5	4,224.1	98.4
Томилолт, зочны зардал	197.1	173.3	87.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,046.4	2,528.2	83.0
Бараа үйлчилгээний бусад зардал	4,229.9	3,894.6	92.1
Татаас	1,874.6	1,855.6	99.0
Урсгал шилжүүлэг	4,422.2	4,338.5	98.1
Хөрөнгийн зардал	13,446.2	8,269.8	61.5
Сум хөгжүүлэх сангийн зээл олголт	2,517.3	1,118.8	44.4

Аудитын илрүүлэлт:

- Төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй 74.4 сая төгрөгийн, төсвийг үр ашиггүй зарцуулсан 52.9 сая төгрөгийн нийт 127.3 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг дахин даван гаргахгүй байх зөвлөмжийг төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар өгсөн болно.

Дээрх зөрчил нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй бөгөөд Төрийн сан, Санхүүгийн алба, Санхүүгийн хяналт, аудитын алба, төсвийн захирагчдын дотоод хяналт сулаас шалтгаалсан байна.



Тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулалтын талаар:

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Тусгай зориулалтын байгууллагын шилжүүлгийн зарлага 72,672.6 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 71,893.9 сая төгрөгийн зарлага гарч, 776.6 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна. Төсвийн гүйцэтгэл 98.9 хувьтай байна.

Хүснэгт №-13 Төсвийг сайдын багцаар харуулбал:

/сая төгрөгөөр/

Ерөнхийлөн захирагч	Хөтөлбөрийн зориулалт	2021 оны батлагдсан төсөв	2021 оны зарцуулалт	Зөрүү
Эрүүл мэндийн сайд	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	12,548.4	12,548.4	0.0
БХБС	Газрын харилцаа, кадастрын тусгай зориулалт	580.1	578.9	1.2
БСШУС	Сургуулийн өмнөх боловсрол	16,557.3	16,237.4	319.9
БСШУС	Ерөнхий боловсрол	42,198.3	41,768.5	429.8
БСШУС	Насан туршийн болон албан бус боловсрол	492.0	473.3	18.7
ХНХС	Хүүхдийн хөгжил хамгаалал	296.5	289.5	7.0
Нийт дүн		72,672.6	71,893.9	776.6

Аймгийн тусгай зориулалттай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарцуулалтын 56.9 хувийг ерөнхий боловсролын сургууль, 21.4 хувийг СӨБ, 14.6 хувийг Эрүүл мэндийн байгууллагууд, 7.1 хувийг бусад тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Нэг хүүхдэд ногдох норматив зардлыг хэтрүүлэн зарцуулсан 30.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд шууд захирагчид зөвлөмж өгч ажилласан байна. Энэ зөрчил нь Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор баталсан “Хоолны зардлын норматив тогтоох тухай”-тай нийцэхгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл: Аймгийн орон нутгийн хөгжлийн санд 9,641.3 санд төвлөрч аймгийн орон нутгийн хөгжлийн санд 5356.9 сая төгрөгийн, сумын орон нутгийн хөгжлийн санд 4,284.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 3,198.3 сая төгрөгийн, сумын орон нутгийн хөгжлийн сангаас 2,193.8 сая төгрөг зарцуулж нийт 4,249.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа нь тайлант хугацаанд төлөвлөсөн төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй, төсвийн гүйцэтгэлийн хангаагүйтэй холбоотой байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар хөрөнгийн зарцуулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилтийг дэлгэрэнгүй үзэх болно.

Халамжийн сангийн гүйцэтгэл: 2020 онд Халамжийн сангийн зарлагыг аймгийн ИТХ-аар 962,6 сая төгрөгөөр төлөвлөснөөс 959,9 сая төгрөгийн санхүүжилт олгож 2.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Засаг дарга дансны гүйцэтгэл: Аймгийн ИТХ-ын тогтоолоор аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний зардалд 1,297.8 сая төгрөг баталж, 1,083.0 сая төгрөг зарцуулж 214.8 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлын талаар:

Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын дагуу Засаг даргын нөөц хөрөнгийг Орон нутгийн нөөц хөрөнгө дансанд 1,076.7 сая төгрөг төвлөрснийг дараах зориулалтаар зарцуулсан байна. Үүнд:



1. Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгахад 947.5 сая төгрөг,
2. Байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэхэд 43.1 сая төгрөг
3. Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд 32.3 сая төгрөг
4. Шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгт 53.8 сая төгрөг

Мал хамгаалах сангийн гүйцэтгэл: Аймгийн Мал хамгаалах сангийн батлагдсан төсөв 263.5 сая төгрөг, гүйцэтгэл 251.7 сая төгрөг болж орон нутгийн төсвөөс 150.0 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоо 102.3 сая төгрөг, урьд оны төвийн үлдэгдлээс 11.2 сая төгрөгөөр тус тус санхүүжсэн байна.

Авто замын сангийн гүйцэтгэл: Аймгийн ИТХ-аар авто замын сангийн хөрөнгөөр 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 837.9 сая төгрөг баталснаас, гүйцэтгэлээр 680.0 сая төгрөгийг зарцуулж, 157.9 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг орон нутгийн ерөнхий орлогод татан төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөлт гүйцэтгэлийн талаар:

Орон нутгийн хөрөнгө оруулалтын дансанд 974.1 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 708.9 сая төгрөгийг гүйцэтгэлээр санхүүжиж 265.2 сая төгрөгийн үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

Төлөвлөсөн 12 төсөл, арга хэмжээнээс 249.6 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас АЗДТГ-ын хэрэгцээнд 195.0 сая төгрөгөөр автомашин худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалттай нийцэхгүй байна.

Түрээсийн орон сууцны сангийн төсвийн гүйцэтгэл: Түрээсийн орон сууцны эргэлтийн санд 16.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 68.3 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрч 15.0 сая төгрөгийн зардал гаргаж 53.3 сая төгрөгийг орон сууцны үнэнд Хөгжлийн банканд шилжүүлсэн байна.

Жижиг дунд үйлдвэржилтийг хөгжүүлэх сангийн талаар: Орон нутгийн төсөвт төлөвлөөгүй, төсвийн гүйцэтгэл тайлагнаагүй байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын талаар:

Байгал хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 1,300.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас сумдад 569.8 сая төгрөг, аймагт 730.9 сая төгрөгийн 37 арга хэмжээ хэрэгжүүлэхээр АИТХ-ын хуралдаанаар баталсан байна.

Аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөө 730.9 сая төгрөг, гүйцэтгэл 162.6 сая төгрөг зарцуулж үлдэгдэл 568.3 сая төгрөгийг аймгийн ерөнхий орлогын дансанд буцаан зарцуулсан байна. Энэ нь Ковид-19 цар тахлын улмаас хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүйтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 5.8 сая төгрөгийг зөвлөгөөний хоолны зардалд, өмнөх оны хоолны зардлын өр төлбөрийн үлдэгдэлд 0.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолоор баталсан эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлангийн талаар:



Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолоор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж төсөвт тодотгол хийсэн 2021 оны 01 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байна.

Хүснэгт №-14 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэлийг харуулбал /сая.төгрөг/

№	Хөтөлбөрийн нэр	Төлөвлөгөө		Гүйцэтгэл	
		Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шилжих хөрөнгө оруулалт	32	1,860.2	56	3,637.7
2	Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт	16	2,398.9	10	829.4
3	аймгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт	8	713.0	5	120.0
4	Аймгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар	12	428.2	27	750.5
5	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих			30	10,670.0
6	Мал хамгаалах сан			1	240.0
7	Зураг төслийн сан			39	818.6
8	Чанарын баталгааны барьцаа хөрөнгөөр хэрэгжих			1	207.1
9	Захиалагчийн хяналтын зардлаар хэрэгжих			3	68.3
10	Ажлын гүйцэтгэлээр хэрэгжих зураг, төсөл			8	13.6
Нийт		68	5,400.3	180	17,355.2

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 5,400.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 68 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөж, гүйцэтгэлээр 17,355.2 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ороогүй 11,954.9 сая төгрөгийн 112 худалдан авах ажиллагаа зохион байгуулсан нь тайлант онд хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа хангалттай тооцоо, судалгаа хийгээгүй, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Худалдан авах ажиллагааг аймгийн хэмжээнд цахимаар зохион байгуулж 17,355.2 сая төгрөгийн 180 тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажиллаж, 11,897.6 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны гэрээг байгуулж, төлөвлөсөн 21 төсөл арга хэмжээтэй холбоотой 654.6 сая төгрөгийн ХАА зохион байгуулаагүй байна.
- Аймгийн Цагдаагийн газрын Хатгал тосгон дахь сургалтын төвийн байрны засварын зардалд 30.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 24.4.”Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” заалтыг зөрчсөн байна

Техникийн хяналтын зардлын талаар:

Аймгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээс тооцох техникийн хяналтын зардлыг орон нутгийн орлогод төлөвлөөгүй, гүйцэтгэлээр орлого 319.9 сая төгрөг, зардал 413.4 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Техникийн хяналтын зардлаас захиалагчийн хяналт хариуцсан ажилтныг гэрээгээр ажиллуулж 7.0 сая төгрөгийн цалин олгосон; /зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн/
- Захиалагчийн хяналтын зардлаас аймгийн Орон нутгийн өмчийн газрын бичиг хэргийн зардалд 8.2 сая төгрөг зарцуулсан;
- ЗД-ын 2021 оны А/273 захирамжийн дагуу нийт 28.7 сая төгрөгийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт гүйцэтгэлээр санхүүжүүлээгүй;



- Техникийн хяналтын зардлыг орон нутгийн 2021 оны төсөвт төлөвлөөгүй;
- "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-ын даргын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 05 дугаар тушаалаар нэр бүхий 4 инженер томилон ажиллаагүй байхад даатгалын зардалд 1.0 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 2.2 сая төгрөг, ХХОАТ-т 1.0 сая төгрөг нийт 4.2 сая төгрөгийн зардал гаргасныг төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн байна.

Бүтэц орон тооны талаар: ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад нийт 5,582 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 5,580 орон тоотой ажилласнаар нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан байна.

Хүснэгт №-15 Орон тооны мэдээлэл

№	Ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Удирдах ажилтан	363	361	-2
2	Гүйцэтгэх ажилтан	3,378	3,378	0
3	Үйлчлэх ажилтан	1,778	1,776	-2
4	Гэрээт ажилтан	63	65	2
Дүн		5,582	5,580	2

Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд 2 орон тоо хэмнэсэн харагдаж байгаа боловч төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Мөрөн сумын 2 дугаар сургууль 3 орон тоо хэтрүүлсэн байна.
2. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны Б/123 тоот тушаалаар тус газрын орон тоог 45 албан хаагчаар тогтоосон байна. Харин 2021 оны орон тоог 40 албан хаагчаар тогтоож цалингийн сан баталсан байна. Тайлант онд гүйцэтгэлээр 47 орон тоо ажиллаж, 7 орон тоог нэмэлт санхүүжилтийн орлогоос цалинжуулсан байна.

